



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, 2025 оны 120 дүгээр тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 5 байршлын 5 нэгж талбарт газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр цахим хэлбэрээр зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээ анхны үнийг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
Х/105 дугаар захирамжийн хавсралт

ЦАХИМ ХЭЛБЭЭРИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, АНХНЫ ҮНЭ

№	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ (м2-аар)	Газрын анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн төлбөр 10% (төгрөг)
1	БХД 1-р хороо, Өндөртолгой, Цагдаагийн барилгын хойд талд	Үйлчилгээтэй орон сууц	3877	4,652,400	465,240
2	БХД 1-р хороо, Саалийн толгойн баруун урд талд	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	98283	35,381,880	3,538,188
3	БХД 1-р хороо, Ногооны талбайд	Төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан	5966	103,779	10377.9
4	БХД 2-р хороо, Замчин	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	258	309,600	30,960
5	БХД 2-р хороо, Билгүүт	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	3011	3,613,200	361,320